

ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ: ХЯНАЛТ ТАВИХ

№	Үндсэн чиг үүрэг	№	ДЭД ЧИГ ҮҮРЭГ	Хамтран хэрэгжүүлэгч
1	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	1	Засгийн газар дахь байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг үнэлэх ажлыг улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, биелэлтэд нь хяналт тавьж, мэдээлэх	ТЗБ, албан тушаалтан аймаг, нийслэлийн ЗДТГ
		2	Хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлан, мэдээлэл ирүүлэх, явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	ТЗБ, албан тушаалтан аймаг, нийслэлийн ЗДТГ
		3	Төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах	ТЗБ, албан тушаалтан аймаг, нийслэлийн ЗДТГ
		4	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	ТЗБ, албан тушаалтан аймаг, нийслэлийн ЗДТГ
		5	Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг Засгийн газарт танилцуулж, хэлэлцүүлэх	ЗГХЭГ
		6	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргах	ТЗБ, албан тушаалтан аймаг, нийслэлийн ЗДТГ

		7	Засгийн газар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт, түүний явцын талаар Улсын Их Хуралд тогтоосон хугацаанд танилцуулах	ТЗБ, албан тушаалтан аймаг, нийслэлийн ЗДТГ
		8	Захиргааны хэм хэмжээний актад жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	*
2	Тандалт судалгаа хийх	9	Хэрэглэгчийн үнэлгээний судалгаа зэргийг үндэслэн тандалт судалгаа хийх	ТЗБ, албан тушаалтан аймаг, нийслэлийн ЗДТГ
		10	Байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд бүтээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулах асуудлаар санал гаргах	ТЗБ
		11	Байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа чанартай, хүртээмжтэй, шуурхай эсэхэд хэрэглэгчийн үнэлгээ авах ажлыг зохион байгуулж дүн шинжилгээ, судалгаа хийх	ТЗБ, хөндлөнгийн судалгааны байгууллага
		12	Өргөдөл, гомдол шийдвэрлэх ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих, өргөдөл, гомдлын агуулгад судалгаа дүгнэлт хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх	ТЗБ, албан тушаалтан аймаг, нийслэлийн ЗДТГ
		13	Тандалт судалгааны тайланг тухай бүр Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргад танилцуулах	ХҮҮХ
3	Хяналт шалгалт хийх	14	Засгийн газар дахь байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг хянан шалгах	ЗГ, ХҮҮХ
		15	Дээд шатны байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу хяналт шалгалт хийх	ТЗБ, албан тушаалтан
		16	Хяналт шалгалтын дүнг үндэслэн ахлах хянан шалгагч, ерөнхий хянан шалгагчийн мэдэгдэл, албан шаардлага хүргүүлэх	ТЗБ, албан тушаалтан

		17	Засгийн газар дахь хяналт шалгалтын талаарх дүнг Ерөнхий сайд, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргад, ерөнхий дүнг жил бүр Улсын Их Хуралд танилцуулах	* ЗГХЭГ, ХҮҮХ УИХ
		18	Хяналт шалгалтын дүнг үндэслэн холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах саналыг эрх бүхий этгээдэд хүргүүлэх	*
		19	Хяналт шалгалтын дүн, тайлан, судалгаа болон өөрийн үйл ажиллагаанд хамаарах хуулиар нууцад хамааруулснаас бусад мэдээллийг олон нийт танилцах боломжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх	*
		20	Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг хөтлөх	*
4	Өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэх	21	Байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой асуудлаар гаргасан эсхүл ЗГИОНХТ-өөр дамжуулан гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх	ТЗБ, албан тушаалтан аймаг, нийслэлийн ЗДТГ
		22	ЗГИОНХТ-д ирсэн өргөдөл, гомдол, мэдээллийг тухай бүр холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, өргөдөл гаргагчид холбогдох мэдээллийг бичгээр, цахимаар, биечлэн болон бусад хэлбэрээр өгч ажиллах	ТЗБ, албан тушаалтан аймаг, нийслэлийн ЗДТГ
		23	ЗГИОНХТ-д ирсэн өргөдөл, гомдолд эрх бүхий байгууллага хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариу өгөөгүй тохиолдолд ахлах хянан шалгагчийн албан шаардлагыг холбогдох байгууллагад хүргүүлэх	ТЗБ, албан тушаалтан
		24	Өргөдөл, гомдлыг хянан үзэж захиргааны актыг илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх, захиргааны актыг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгох, зохих акт гаргахыг тухайн захиргааны байгууллагад даалгах, захиргааны актыг өөрчлөх,	*

5	Төрийн байгууллагын хуулиар тогтоосон бусад нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх		захиргааны актыг хэвээр үлдээх шийдвэр гаргах	
		25	Тухайн жилд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх дүн мэдээг жил бүр нийтэд тайлагнах	*
		26	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх	ТЗБ, албан тушаалтан аймаг, нийслэлийн ЗДТГ
		27	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх	АТГ, ТЗБ, албан тушаалтан аймаг, нийслэлийн ЗДТГ
		28	Эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн байдлыг судлан нэгтгэж, холбогдох хууль тогтоомж, шийдвэрийг боловсронгуй болгох саналаа төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх	ТЗБ, албан тушаалтан аймаг, нийслэлийн ЗДТГ
		29	Төсвийн тухай хуульд заасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлах	*
		30	Байгууллагын архивын баримт бичгийг зохион бүрдүүлэх, ангилан төрөлжүүлэх, баримт бичгийг хүлээн авах, бүртгэх, илгээх, хянан шийдвэрлэх, ашиглах, хадгалах, архивт шилжүүлэх.	*
		31	Албан хаагчдын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, нийгмийн баталгааг хангах	*
		32	Салбарын санхүү, төсөв, хөрөнгө оруулалт, байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хууль тогтоомжийн хүрээнд эрхлэх	*
		33	Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх	*

		34	Байгууллагын гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх	*
--	--	----	---	---

Нийт 34 чиг үүргийг чиглэлээр нь:

Хянах 10, зохион байгуулах 9, хэрэгжүүлэх 12, зохицуулах хэлбэрийн 3 чиг үүрэг байна.

	Хянах	10		Хэрэгжүүлэх	12
	Зохион байгуулах	9		Зохицуулах	3

Холбогдох талуудыг тодорхойлох

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын холбогдогч талуудыг тодорхойлохдоо тус байгууллагын бусад байгууллагатай харилцах хуулиар олгогдсон эрх хэмжээнд үндэслэсэн бөгөөд дараах 3 чиглэлээр харилцаж байна.

Хүснэгт 3. Байгууллагын холбогдох талууд

 Дээшээ чиглэлд	Дээд шатны байгууллага, албан тушаалтнаас гаргасан бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, ажлын үр дүнг танилцуулах, тайлагнах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, санал боловсруулж хүргүүлэх, зөвлөгөө, дэмжлэг авах				
 Хэвтээ чиглэлд	Үйл ажиллагаагаа уялдуулах зохицуулах, хамтран ажиллах, санал уламжлах, мэргэжил, арга зүйн дэмжлэг авах				
 Доошоо чиглэлд	Хяналт тавих, нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах, иргэний санал, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, эргэх холбоогоор хангах (Яамд, Агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ, тэдгээрийн албан тушаалтан, Улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн болон төрийн өмчит хуулийн этгээд)				